

УЛААНБААТАР ХОТЫН СҮХБААТАР ДҮҮРГИЙН 20-Р ХОРООНЫ НУТАГ  
ДЭВСГЭРТ БАЙРЛАХ “ОЙМСНЫ ҮЙЛДВЭР” ТӨСЛИЙН 2024 ОНЫ  
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ТӨСЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ .....	2
1.1 Төслийн мэдээлэл .....	2
1.2 Төслийн байршил:.....	2
1.3 Төслийн хүчин чадал .....	3
1.4 Төслийн дэд бүтэц .....	6
ХОЁРДУГААР БҮЛЭГ. ТӨСЛИЙН ГОЛ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ.....	8
ГУРАВДУГААР БҮЛЭГ. БАЙГАЛЬ ОРЧНЫ БҮРЭЛДЭХҮҮН ТУС БҮРЭЭР СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ЗӨВЛӨМЖ .....	10
3.1.1 Агаарын чанар.....	10
3.1.2 Газрын гадарга, хөрсний элэгдэл, эвдрэл .....	10
3.1.3 Химийн бодисыг хадгалахад тавих шаардлага .....	10
3.1.4 Химийн бодисыг тээвэрлэхэд тавигдах шаардлага .....	10
3.1.5 Удирдлага, зохион байгуулалтын талаар .....	12
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ .....	14
Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө .....	14
ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР .....	20

УЛААНБААТАР ХОТЫН СҮХБААТАР ДҮҮРГИЙН 20-Р ХОРООНЫ НУТАГ  
ДЭВСГЭРТ БАЙРЛАХ “ОЙМСНЫ ҮЙЛДВЭР” ТӨСЛИЙН 2024 ОНЫ  
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

**НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ТӨСЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ**

**1.1 Төслийн мэдээлэл**

**Төслийн нэр:**

“Оймсны үйлдвэр” төсөл

**Төслийн зорилго:**

“Янмал” ХХК нь 2005 оноос хойш ноолуурын салбарт тасралтгүй 15 жил үйл ажиллагаа явуулж байна. Тус үйлдвэр нь 60 орчим ажиллагсадтай. Одоо тус үйлдвэр нь эрэгтэй, эмэгтэй, хүүхдийн бүх төрлийн хөвөн даавуун, зузаан, нимгэн, спортын, хонь болон тэмээний ноосон, ямааны ноолууран, сарлагийн хөөврөн оймсыг өнгө загвар, хэмжээний өргөн сонголт, өндөр чанартайгаар төрөл бүрийн оймс үйлдвэрлэж байгаа ба тухайлбал үндэсний ноос, ноолуурын томоохон үйлвэрлэгчид болох "Говь" ХК, "Гоёо" ХК, "Алтай Кашмир" ХХК зэрэг компаниудын захиалгыг чанарын өндөр түвшинд гүйцэтгэж байна.

**Төсөл хэрэгжүүлэгч:**

“ЯНМАЛ” ХХК, Улсын бүртгэлийн дугаар: 9011051008, Регистрийн дугаар: 5011027, Газар эзэмших эрхийн гэрчилгээний дугаар: 1: 000304252, Газар эзэмших эрхийн гэрчилгээний дугаар 2: 000321413, Газар эзэмших эрхийн гэрчилгээний дугаар 3: 000321414

**Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг:**

Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 9-р хороо, Горькийн 16, 374 тоот. Утас1: 99099845, Утас2: 11358000, Захирал Д. Лхагважав

**1.2 Төслийн байршил:**

“ЯНМАЛ” ХХК-ний “Оймсны үйлдвэр” төсөл нь Нийслэлийн Сүхбаатар дүүргийн 20-р хорооны нутагт, байрлах өөрийн эзэмшлийн талбайд үйл ажиллагаагаа явуулж байна.

**Хүснэгт 1. Оймсны үйлдвэрийн талбайн солбилцол**


	Уртраг			Өргөрөг		
	Градус	Минут	Секунд	Градус	Минут	Секунд
1	107	0	11.92	48	2	46.08
2	107	0	12.17	48	2	47.48
3	107	0	15.31	48	2	47.4
4	107	0	15.28	48	2	46.72
5	107	0	15.19	48	2	46.72
6	107	0	15.15	48	2	46.07



Зураг 1. Оймсны үйлдвэрийн байр

### 1.3 Төслийн хүчин чадал

1 машин өдөрт дунджаар 200 хос оймс үйлдвэрлэдэг бөгөөд нийт машинууд тасралтгүй ажиллан өдөрт 11 000 орчим хос оймс үйлдвэрлэдэг байсан ба 2019 оны 12 сард дахин 22 шинэ машин авч шинэ цех нээн үйлдвэрлэлийн хүчин чадлаа 30 гаруй хувиар нэмэгдүүлснээр өдөрт 19 000 хос оймс үйлдвэрлэх боломжтой болж байна. Оймс сүлжих машинуудыг ачааллыг жигдрүүлэх зорилгоор үндсэн 4 цехэд хувааж оёх цехийг хамтад нь шийдсэнээр дамжлага хоорондын ажлын уялдаа холбоог сайжруулан хөдөлмөрийн бүтээмжийг дээшлүүлэх ач холбогдолтой болсон.



Бүдүүвч 1. Үйлдвэрийн шат, дамжлагууд



Зураг 2. Түүхий эд

**УЛААНБААТАР ХОТЫН СҮХБААТАР ДҮҮРГИЙН 20-Р ХОРООНЫ НУТАГ  
ДЭВСГЭРТ БАЙРЛАХ “ОЙМСНЫ ҮЙЛДВЭР” ТӨСЛИЙН 2024 ОНЫ  
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**



**Бүдүүвч 2. Эцсийн бүтээгдэхүүн хүртэлх шат дамжлагууд**

Үйлдвэрлэлийн дамжлага бүрт бүтээгдэхүүний чанарыг ширхэг бүрээр чанарыг шалгадаг ба гологдол, алдаа дутагдал гарвал тэр дор нь засаж залруулан үйлдвэрлэлийн хэвийн тасралтгүй ажиллагааг хангаж ажиллаж байна.

Тасралтгүй ажиллагааг хангахын тулд оймс сүлжих үндсэн цехийг 24 цагийн ажиллагаанд оруулсан ба бусад цехүүд болох оёдол, угаалга, индүүдэх цехийн ажиллах хүчнийг нэмэгдүүлэх, ажиллагсадын ажиллах ур чадвар, хурдыг дээшлүүлэх, өндөр бүтээмжтэй тоног төхөөрөмжөөр тоноглох зэрэг арга хэмжээг байнга хэрэгжүүлж байна.

**Хүснэгт 2. Үйлвэрийн хүчин чадал**

	<b>Гол дамжлагууд</b>	<b>Үйлдвэрлэгч, нэр</b>	<b>Тоног төхөөрөмжийн тоо</b>	<b>Хүчин чадал / хоногт</b>	<b>Машин төхөөрөмжийн насжилт (жил)</b>
1	<i>{Дамжлага 1}</i>				
	Сүлжих цех	Оймс сүлжих үндсэн цех	85	19000 хос	0-5 жил
	Битүүлж оёх	Оёдлын цех	6	24000 хос	1-5 жил
	Угаах	Угаалгын цех	5	25000 хос	3-5 жил
	Индүүдэх	Индүүний цех	1	20000 хос	1 жил
	Трико	Триконы цех	6	5000 ш	1-2 жил

**Оймсны үйлдвэр**

Сүлжих машин нь БНСУ-д үйлдвэрлэгдсэн бөгөөд компьютер удирдлагатай бүрэн автомат машин юм. 24 цагийн тасралтгүй ажиллагаагаар 10 жил ажиллах ба өдөрт 1 машин нь дунджаар 200 хос оймс үйлдвэрлэх хүчин чадалтай ба бид энэхүү хүчин чадлаа бүрэн ашиглаж байна.



Зураг 3. Сүлжих машин

Оймс битүүлж оёх машин нь БНСУ-д үйлдвэрлэгдсэн бөгөөд сүлжих машинаас гарсан оймсны хамрыг битүүлж оёх зориулалттай машин. Манай үйлдвэрт нийт 6 оёх машин байдаг бөгөөд 2-ыг нь нөөцөнд байлгаж яаралтай их хэмжээний захиалгат ажил болон оёх машины эвдрэл гэмтлийн үед ажиллуулахаар зохион байгуулж нөөцөнд байлгадаг. 1 машин өдөрт бүрэн хүчин чадлаараа 3500-4000 хос оймс оёх хүчин чадалтай.



Зураг 4. Оймс битүүлж оёх машин

Оймс угаах болон хатаах төхөөрөмж нь БНХАУ-д үйлдвэрлэгдсэн бөгөөд хоногт 25 мянган хос оймс угааж хатаах хүчин чадалтай. Ноосон оймс, өвдгөвч, түрийг угааж боловсруулна.

Оймс индүүдэх уурын иж бүрэн машин нь БНСУ-д үйлдвэрлэгдсэн бөгөөд өдөрт 20 мянган хос оймс индүүдэх хүчин чадалтай иж бүрэн уурын индүү юм. Уурын индүүгээр индүүдсэнээр оймсны бүтцэд ордог түүхий эдийн эдэлгээг уртасгаж, гоёмсог, чанартай зөв хэлбэртэй индүүдэх ач холбогдолтой. Монгол Улсад одоогоор ийм технологийн индүүний машин байхгүй байгаа.



Зураг 5. Оймс индүүдэх уурын иж бүрэн машин



Зураг 6. Хүүхдийн трико үйлдвэрлэн оёх иж бүрэн шугам

Хүүхдийн трико үйлдвэрлэн оёх иж бүрэн шугам нь БНСУ-д үйлдвэрлэгдсэн бөгөөд битүүлж холбож оёх, захлан оёх, резин оёх, эсгүүр, индүүдэх гэсэн дамжлагуудтай иж бүрэн шугам юм. Хоногт 500 трико үйлдвэрлэх хүчин чадалтай. Эх бие болон бусад деталиудыг өөрийн оймсны машин дээр хийдэг ба эдгээр машинууд нь деталиудыг эсгэн хооронд нь холбож, резин хийж индүүдэн бэлэн болгох процесс явагддаг.

100%-ийн хөвөн даавуун утсаар хийж байгаа болохоор хүүхдэд харшлахгүй, чанартай бөх бат трико болсон ба чанарын хувьд импортын триконуудаас илүү байгаа нь зах зээлийн болон хэрэглэгчийн судалгаагаар батлагдсан болно. Оймсны үйлдвэрт ноос ноолуур угаах бэлэн бүтээгдэхүүний угаахад ашигладаг шингэн саванг “Херроу” ХХК авдаг болно.

**УЛААНБААТАР ХОТЫН СҮХБААТАР ДҮҮРГИЙН 20-Р ХОРООНЫ НУТАГ  
ДЭВСГЭРТ БАЙРЛАХ “ОЙМСНЫ ҮЙЛДВЭР” ТӨСЛИЙН 2024 ОНЫ  
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

**1.4 Төслийн дэд бүтэц**

“ЯНМАЛ” ХХК-ийн үйлдвэр нь Улаанбаатар хотын Сүхбаатар дүүргийн 20-р хорооны нутаг дэвсгэрт оршиж байгаа бөгөөд засмал замаар холбогдсон, 380Вт-ын цахилгаан дамжуулах агаарын шугамд холбогдсон, халуун болон хүйтэн усны сүлжээнд холбогдсон, дэд бүтэц сайтай газар байна.

**Цахилгаан эрчим хүч** - Нийслэл хотын төвийн шугам сүлжээнд холбосон. Оймсны үйлдвэр нь цахилгаан эрчим хүчийг үйлдвэрийн гадна дотор гэрэлтүүлэг, агааржуулалт, холбооны ахуйн хэрэглээнд, цэвэр усыг зөвхөн ахуйн хэрэглээнд ашиглах юм.



Зураг 7. Галаас урьдчилан сэргийлэх самбар болон аюулгүй ажиллагааны самбар

**Унд ахуйн хэрэглээний цэвэр ус** - Төвлөрсөн системд холбогдсон байна.

*Цэвэр ус* – Ажилчдын унд ахуйн хэрэглээний цэвэр усыг [Улаанбаатар хотын төвлөрсөн шугам сүлжээнээс хангана](#). Төсөлд нийт 60 хүн ажиллана. Нэг хүний ус хэрэглээний норм хоногт ахуйн хэрэгцээнд 200 л ус хэрэглэнэ гэж тооцоход хоногт 0.6 м<sup>3</sup> жилд 219 м<sup>3</sup> ус ашиглахаар байна. (\*- *БОНХАЖ-ын сайдын 2015 оны А/301 дүгээр тушаалын 12 дугаар хавсралт* – “Орон сууц, нийтийн байр, гэр хорооллын усны норм”, *Төвлөрсөн ус хангамж, ариутгах татуургын төвлөрсөн системд холбогдсон орон сууц – 200л/хоног/хүн*)

Хүснэгт 3. Төслийн ажилчдын унд ахуйн усны тооцоо

Усны хэрэглээний төрөл	Төслийн хугацаа, хон/жил	Хүний тоо	Ус хэрэглээ	
			м <sup>3</sup> /хон	м <sup>3</sup> /жил
Унд-Ахуйн	365	60	36	13,140
Ээрмэлийн үйлдвэр				

**Хог хаягдал**

Хатуу, шингэн хог хаягдал нь хүн ам, үйлдвэрлэлд хэрэгцээт газрын нөөцийг багасгах, хөрс, ус, агаарыг хорт бодис, хүнд металл, нян вирусээр бохирдуулагч гол эх үүсвэр болдог. Хатуу хог хаягдал нь удаан задарч бодисын эргэлтэд аажмаар орох ба задрах хугацаа нь удаан байдаг учраас байгаль орчинд хор хөнөөлтэй.

Төслийн үйл ажиллагааны явцад гарах хог хаягдал нь ахуйн болон технологийн үйл ажиллагаанаас үүснэ. Хэлбэрээр нь:

1. Хатуу
2. Шингэн
3. Хийн гэж ангилна.

УЛААНБААТАР ХОТЫН СҮХБААТАР ДҮҮРГИЙН 20-Р ХОРООНЫ НУТАГ  
ДЭВСГЭРТ БАЙРЛАХ “ОЙМСНЫ ҮЙЛДВЭР” ТӨСЛИЙН 2024 ОНЫ  
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

**Хатуу хог хаягдал**

Хатуу хог хаягдлын менежментийн үндсэн зарчим нь эх үүсвэрийг хязгаарлах, хаягдлыг тусгайлсан горимын дагуу байгаль орчин, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй хэлбэрээр цуглуулах, хог хаягдлыг богино хугацаанд зайлуулан, орчныг цэвэрлэх зэрэг арга хэмжээнд тулгуурлана.

**Ахуйн гаралтай хатуу хог хаягдал:** Тус төслөөс гарах ахуйн гаралтай хатуу хог хаягдлын эх үүсвэр нь ажилчдын хэрэглээ, хоол бэлтгэлийн явц байх болно. Хатуу хог хаягдлын дийлэнх хувийг сав баглаа боодол эзэлнэ.

- Байгууламжийн үйл ажиллагаанаас доорх нэр төрлийн хатуу хог хаягдал гарна.
- Хүнсний зүйлсийн сав, баглаа боодол
- Бие засах газрын хаягдал
- Ундааны сав, лааз
- Хоолны үлдэгдэл

Тус төсөлд 1 хүнээс өдөрт дунджаар 0,3 кг хог хаягдал үүсдэг гэдгийг тооцвол үйлдвэрийн хувьд өдөрт 60 хүн ажиллаж, хоногт үүсэх ахуйн гаралтай хог хаягдлын хэмжээ нь 18 кг, сард 450 кг гарах ба үүнийгээ тусгай зориулалтын тагтай саванд хадгалж байгаад СБДүүргийн 20-р хороотой гэрээ байгуулан ачуулж зайлуулдаг.

**Технологийн хаягдал:** Төслийн технологийн үйл ажиллагаанаас хатуу хаягдал гарахгүй бөгөөд зөвхөн ахуйн гаралтай хатуу хог хаягдал гарна. Химийн бодисын сав баглааны бүрэн бүтэн байдалд байнгын хяналт тавин ажиллах нөхцөлд технологийн хатуу хаягдал гарахгүй болно. Бүтээгдэхүүний сав, баглаа, боодол зэргийг устгах, хадгалахдаа “Химийн хорт болон аюултай бодисын тухай” хуулийн 14.1-т заасны дагуу 2017 оны 5 сарын 12-ны өдрийн “Хог хаягдлын тухай” хуулийн, Аюултай хог хаягдал хадгалах, устгах тогтоомжийн дагуу ажиллах шаардлагатай.

**Шингэн хаягдал:** Технологийн үйл ажиллагаанаас шингэн хаягдал гарахгүй бөгөөд зөвхөн ахуйн гаралтай шингэн хаягдал гарна. Үйлдвэрийн ажилчдын шингэн хаягдлыг доторлогоотй цооногт хуримтлуулан соруулан зайлуулдаг.

**УЛААНБААТАР ХОТЫН СҮХБААТАР ДҮҮРГИЙН 20-Р ХОРООНЫ НУТАГ  
ДЭВСГЭРТ БАЙРЛАХ “ОЙМСНЫ ҮЙЛДВЭР” ТӨСЛИЙН 2024 ОНЫ  
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

**ХОЁРДУГААР БҮЛЭГ. ТӨСЛИЙН ГОЛ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ**

Дээр өгүүлсэн болзошгүй нөлөөллийн судалгааны үр дүнгээс үзвэл оймсны үйлдвэрийн үйл ажиллагааны явцад газрын гадаргуу, хөрс, агаар бохирдох зэрэг нөлөөллүүд нь аюулгүй ажиллагааны дүрэм журмыг баримтлаагүйгээс үүсэх нөлөөллүүд байна.

Голлох нөлөөллийг тодорхойлохдоо:

1. Гарч болох бохирдлын түвшинг харгалзан үзэх
2. Сөрөг нөлөөллийн үр дагаврыг бууруулах арга замыг эрж хайхад шаардлагатай мэдээллийг бүрдүүлэх
3. Сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, түүнээс урьдчилан сэргийлэх арга замын талаар зөвлөмж боловсруулж өгөх явдал юм.

Эдгээр нөлөөллийг бууруулах, үүсэхгүй байх боломжтой бөгөөд төслийн үйл ажиллагааны үед үүсэх гол нөлөөллийг химийн бодисын асгаралт, алдагдалаас үүсэх аюул байна гэж үзлээ. Ингээд энэ нөлөөллийн талаар эрсдлийн үнэлгээний хэсэгт аргачлалын дагуу тусгайлан тооцож үнэлсэн болно.

Хүснэгт 4. Төслийн голлох сөрөг нөлөөлөл

Эх үүсвэр	Хөрс	Агаар	Эдэлбэр газар
<b>Химийн түүхий эдийн сав, боодлын хаягдал</b>	Химийн бодисын хаягдал сав, баглаа боодлын хаягдал		
<b>Үйлдвэр болон орчны тоосжилт</b>	Үйлдвэрийн тоног төхөөрөмжийн битүүмжлэл сайн байх боловч ноос нооллуураар сүлжих оёх үед их хэмжээний нарийн ширхэглэг бүхий тоосжилт үүсч байдаг		
<b>Ахуйн хог хаягдал үүсэх</b>	Төслийн дэд бүтэц дээр дурдсан хог хаягдлын судалгаанаас үзвэл өдөрт 0.9 кг, 1 жилийн хугацаанд 324 кг ахуйн хатуу хог хаягдал гарах болно.		
<b>Төслөөс үзүүлэх дуу чимээ</b>		Үйлдвэрийн дотоод агаар орчинд дуу чимээний тархалт үүснэ.	

***Хөрсний элэгдэл, бохирдол***

“ЯНМАЛ” ХХК-ийн оймсны үйлдвэрийн үйл ажиллагаа нь хөрсний элэгдэл, бохирдолд шууд нөлөөлөхгүй боловч үйлдвэрийн орчны газрын хөрс, зам талбайг тохижуулж зүлэгжүүлээгүйгээс хүн, автомашины хөдөлгөөнд өртөн элэгдэлд орох, ил задгай хог хаягдлын цэг байгуулах болон түүнийг ариутгахгүй удах, хогийг зохих график хуваарийн дагуу ачихгүй байх, химийн бодис, материалыг тээвэрлэн зөөх, ачих, буулгах үедээ санамсаргүй алдаж асгах зэрэг шалтгаанаас хөрс бохирдох сөрөг нөлөөлөл гарах магадлалтай байна. Иймээс хүний үйл ажиллагаатай холбогдож гарч болох эдгээр сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, орчны зам талбайг тохижуулж зүлэгжүүлэх, зарим хэсгийг нь хатуу хучилттай болгох, хогийн түр цэгийг шаардлагын дагуу байгуулах, хогийг ойр ойрхон хугацаанд бүрхүүлтэй машинаар зөөж хаяулах, химийн бодисыг зөөх, буулгахдаа шаардагдах техник хэрэгслийг ашиглан маш анхаарал болгоомжтой, ажлын зориулалтын хувцастайгаар ажиллах шаардлагатай юм.

***Агаарын химийн бохирдол***

Агаар бохирдуулах үндсэн эх үүсвэрийг байгалийн гаралтай, хүний үйл ажиллагаанаас үүдэлтэй гэж 2 ерөнхий хэсэгт хувааж үздэг. “ЯНМАЛ” ХХК-ийн үйлдвэрийн үйл ажиллагааны улмаас орчны хөрс эвдэрч тоосжилт нэмэгдэх, химийн бодис тээвэрлэх, ачих, буулгах, зөөх, хадгалах үеийн ууршилтаас гарах хий, хатуу бодисын тоос нь агаарын чанарт нөлөөлөх боловч хөдөлмөр хамгаалалын дүрмийг баримтлан ажилсанаар энэхүү нөлөөлөл маш бага байх болно.

Иймд импортоор авчран борлуулж буй химийн бодисын сав, баглаа боодлын бүрэн бүтэн байдалд байнга хяналт тавих, химийн бодисын алдагдал, ууршилт гарахаас сэргийлэх, ажиллагсдыг



УЛААНБААТАР ХОТЫН СҮХБААТАР ДҮҮРГИЙН 20-Р ХОРООНЫ НУТАГ  
ДЭВСГЭРТ БАЙРЛАХ “ОЙМСНЫ ҮЙЛДВЭР” ТӨСЛИЙН 2024 ОНЫ  
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

хөдөлмөр хамгааллын зориулалтын хувцсаар хангах, үйлдвэрт агааржуулалтын төхөөрөмж тавих, татах шүүгээ байрлуулах, ажилчдын хувцас солих өрөө гаргаж тохижуулах, ажлын байрны агаар дахь химийн хорт бодисын агууламжийг хянах багаж хэрэгсэлтэй болох зэрэг арга хэмжээг цаашдын төлөвлөгөөндөө тусгаж хэрэгжүүлэхийг зөвлөж байна.

HT-9600 Агаарын чанарын хянагч чийгшил, температур хэмжигч, PM2.5 PM10 агаарын чанарын хэмжигч багажаар үйлдвэр дотор, гадаа агаарын тоосжилтын хэмжээг хэмжсэн.



- Цэвэр орчинд нэг ширхэгийн хэмжээ, ширхэгийн диаметрийн тархалтыг хэмжихэд ихэвчлэн ашигладаг.
- Ажиллуулахад хялбар, тогтвортой ажиллагаатай.
- Эмийн үйлдвэр, электрон үйлдвэрлэл, нарийн машин механизм гэх мэт салбарт өргөн хэрэглэгддэг.
- Гэр доторх болон гадаа амьдрах орчныг тодорхойлоход тохиромжтой.

Зураг 8. Агаарын чанарын хэмжилт хийсэн багаж



Зураг 9. “Янмал” ХХК-ийн самнах, оймсны, ээрэх үйлдвэрийн дотор явуулсан агаар чанарын хяналт шинжилгээ

**ГУРАВДУГААР БҮЛЭГ. БАЙГАЛЬ ОРЧНЫ БҮРЭЛДЭХҮҮН ТУС БҮРЭЭР СӨРӨГ  
НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ЗӨВЛӨМЖ**

**3.1.1 Агаарын чанар**

- ✓ Хог хаягдал шатаахыг хориглож ажиллах
- ✓ Тээврийн хэрэгслийг асаалттай орхихгүй байх
- ✓ Ажлын байранд агааржуулалтыг 3-4 цаг тутам хийж байхаар орчин үеийн дэвшилтэт агааржуулалтын системийг сонгон авах
- ✓ Ажлын байранд таазны сэнс тавих, дотоод агаарыг чийгшүүлэх арга хэмжээ /нойтон цэвэрлэгээ гэх мэт / тогтмол авч хэрэгжүүлэх
- ✓ Ажилтан, ажиллагсад амны хаалт тогтмол хэрэглэж хэвших

**3.1.2 Газрын гадарга, хөрсний элэгдэл, эвдрэл**

Хөрсний нөөцийг хамгаалах нөлөөллийг бууруулах арга хэмжээ нь ургамал, усны нөөцийг хамгаалах үйл ажиллагаатай нягт уялдаатай юм. Хөрсөн бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, урьдчилан сэргийлэх зорилгоор дараах арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллах нь зүйтэй.

- Хатуу хог хаягдлын зориулалтын цэг байгуулах
- Нөлөөлөлд өртөөгүй талбайд мод бут тарьж цэцэрлэгжүүлэх
- Хатуу хучилттай хийгдсэнээс бусад нөлөөлөлд өртсөн сул талбайн хөрсийг сийрүүлэн шимт хөрсөөр 20 см хүртэл зузаантай хучилт хийж ургамалжуулах

Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах чиглэлээр дээрх зөвлөмжүүдэд тулгуурлан байгаль орчны менежментийн төлөвлөгөө болон орчны хяналт шинжилгээний хөтөлбөр боловсруулагдсан тул төсөл хэрэгжүүлэх хугацаандаа тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг дээрх хөтөлбөр төлөвлөгөөтэй уялдуулан боловсруулж, БОАЖЯ-аар батлуулан мөрдөж ажиллах шаардлагатай.

**3.1.3 Химийн бодисыг хадгалахад тавих шаардлага**

- ✓ Үйлдвэрийн талбай нь гэрэлтүүлэгтэй, химийн бодис, химийн бүтээгдэхүүн асгарах үед зайлшгүй хэрэглэх шаардлагатай багаж хэрэгсэл, цэвэрлэгээний бодисыг бэлтгэсэн байх шаардлагатай.
- ✓ Химийн хортой болон аюултай бодис экспортлох, импортлох, худалдах, ашиглах, үйлдвэрлэх, устгах зөвшөөрөл бүхий иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь химийн хорт болон аюултай бодисыг хадгалахдаа мөн дараах шаардлагыг биелүүлсэн байна.
- ✓ Химийн хорт болон аюултай химийн бодисыг зориулалтын агуулахад, хор аюулын лавлах мэдээлэлд заасан нөхцөлд хадгална.
- ✓ Үйлдвэр нь галд тэсвэржилтийн зэргийг хангахуйц материал, хийцтэй, болзошгүй ослын үед хөрсөнд болон гадагш бодис алдагдахааргүй шал (цементэн болон плитан), бат бэх хамгаалалт бүхий цонх, хаалга, үерийн далан, хамгаалалтын сувагтай байна.
- ✓ Хорт болон аюултай химийн бодисыг шинж чанар, үзүүлэх хор нөлөөллөөс нь хамаарч хавсралтад заасан нөхцөлийн дагуу тусгаарлан хадгална.

**3.1.4 Химийн бодисыг тээвэрлэхэд тавигдах шаардлага**

Химийн хорт болон аюултай бодисыг анхааруулах аюулын шинж чанарын тухай санамж байрлуулсан, техникийн болон аюулгүйн шаардлага хангасан зориулалтын буюу тухайн ачааг тээвэрлэхэд тусгайлан бэлтгэсэн тээврийн хэрэгслээр зөвхөн тогтоосон маршрутын дагуу тухайн бодисын хор аюулын лавлах мэдээлэлд заасан зааврын дагуу тээвэрлэнэ.

Химийн хорт болон аюултай ачаа тээвэрлэх тээврийн хэрэгслийн хурд 25-30 км/цаг- аас хэтрэхгүй, 2 тээврийн хэрэгслийн хоорондын зай 50 метрээс багагүй байвал зохино.

Тээвэрлэлтийн явцад болзошгүй аюул учирсан тохиолдолд хэрэглэх хор уршгийг арилгах

УЛААНБААТАР ХОТЫН СҮХБААТАР ДҮҮРГИЙН 20-Р ХОРООНЫ НУТАГ  
ДЭВСГЭРТ БАЙРЛАХ “ОЙМСНЫ ҮЙЛДВЭР” ТӨСЛИЙН 2024 ОНЫ  
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

зориулалтын багаж, хэрэгсэл /галын хор, хүрз, лоом, сүх зэрэг багаж хэрэгсэл, шуудайтай элс, хувин гэх мэт/, хор саармагжуулах бодис, уусмалаар хангагдсан байна. Тээврийн хэрэгслийн утааны янданг радиоторын тал руу байрлуулна.

- Химийн бодис, бүтээгдэхүүнийг ачих, тээвэрлэх, буулгах ажлыг ачаалал, хөл хөдөлгөөн харьцангуй багатай үед гүйцэтгэх нь тохиромжтой.
- Тээвэрлэх, ачих, буулгах үеийн аюулгүй ажиллагааг химийн хорт болон аюултай бодисыг тээвэрлэх, ашиглах, устгах үйл ажиллагааг гүйцэтгэгч хариуцна.
- Тээвэрлэлтийн үед ачаа унах, сав баглаа боодол гэмтэх, холилдохоос урьдчилан сэргийлж тэдгээрийг зөв байрлуулж, хөдөлгөөнгүй сайтар бэхэлж ачих ба шингэн бодисын хувьд савны амыг дээш харуулан босоогоор байрлуулна.
- Химийн хорт болон аюултай бодисын ангиллын "А" зэрэглэлийн бодисыг зөвхөн өдрийн цагаар ачиж буулгах ба энэ үед хор аюулын лавлах мэдээлэлд заасан зааврыг хатуу сахина.
- Химийн хорт болон аюултай бодисын хайрцаг, сав нь гэмтэлтэй, тээврийн хэрэгсэл бүрэн бус, баримт бичиг зөрчилтэй, анхааруулга, тэмдэг тэмдэглээгүй байвал тээвэрлэлт хийхийг хориглоно.
- Химийн хорт болон аюултай бодисыг тээвэрлэх тээврийн хэрэгслийн жолооч болон түүнийг дагалдан явах ажилтанд химийн бодис бүрийн хор аюулын лавлах мэдээлэл, аюулгүй ажиллагааны зааварчилгаа, болзошгүй ослын үед ажиллах төлөвлөгөө, тээвэрлэх маршрут зэргийг танилцуулж, гарын үсэг зуруулна.
- Тээвэрлэх үед бодисын сав баглаа, боодлын битүүмжлэл алдагдах, ачаа нурах зэрэг зогсох шаардлага гарсан тохиолдолд уг аюултай ачааг тээвэрлэж яваа тээврийн хэрэгслээс хоёр тийш 100 м зайд **"Орохыг хориглоно"** тэмдгийг байрлуулна.
- Химийн хорт болон аюултай бодис тээвэрлэх маршрутыг аль болох хөдөлгөөн багатай, тэгш сайн байхаар сонгож, хэзээ, хаанаас тээвэрлэх талаархи мэдээллийг тухайн орон нутгийн онцгой байдлын асуудал эрхэлсэн болон замын цагдаагийн байгууллагад урьдчилан мэдэгдэж зөвшөөрөл авах ба аюулгүй байдлыг хангуулсан байна.
- Химийн хорт болон аюултай бодис тээвэрлэсэн тээврийн хэрэгслийг сайтар цэвэрлэж, хоргүйжүүлнэ.
- Ашиглах үйл ажиллагаа эрхлэгч нь химийн хорт болон аюултай бодисыг тээвэрлэх үйл ажиллагааг 2 талын хооронд байгуулсан гэрээний дагуу өөр байгууллагаар гүйцэтгүүлж болно. Тээвэрлэгч нь энэхүү журамд заасан шаардлагыг биелүүлж, тээвэрлэлтийн үеийн аюулгүй ажиллагааг хангаж ажиллах үүрэг хүлээнэ.
- Химийн хорт болон аюултай бодисыг хүн, мал, амьтан болон өөр бүтээгдэхүүнтэй хамт тээвэрлэхийг хориглоно.
- Химийн хорт болон аюултай бодисыг цуваагаар тээвэрлэх үед дараах шаардлагыг биелүүлнэ:
  - Тээвэрлэлтийн аюулгүй байдлыг хариуцахаар томилогдсон ажилтан (цувааны ахлагч) цувааг зохион байгуулж, зөвшөөрөгдсөн маршрутын дагуу замын хөдөлгөөний дүрмийг баримтлан, химийн хорт болон аюултай бодисыг тээвэрлэх үйл ажиллагааг удирдана.
  - Цувааны ахлагч цувааны эхний машинд явах бөгөөд тээвэрлэж буй ачаа, цаг агаарын нөхцөл, цуваанд яваа техник хэрэгслийн байдал зэргийг харгалзан бүх төрлийн замд хурд ба машин хоорондын зайг тохируулж явах үүрэгтэй:
  - Цувааны эхний болон сүүлчийн тээврийн хэрэгсэл "цуваа" гэсэн тод бичигтэй байх ба цуваанд эзлэх дугаарыг тээврийн хэрэгсэл бүрийн урд болон ард талд харагдахуйцаар жигд байрлуулна;
- Химийн хорт болон аюултай бодис тээвэрлэх цувааны эхэнд хамгаалалтын машин,

УЛААНБААТАР ХОТЫН СҮХБААТАР ДҮҮРГИЙН 20-Р ХОРООНЫ НУТАГ  
ДЭВСГЭРТ БАЙРЛАХ “ОЙМСНЫ ҮЙЛДВЭР” ТӨСЛИЙН 2024 ОНЫ  
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

төгсгөлд нөөц тээврийн хэрэгсэл явах ба өдрийн цагт ойрын гэрлээ асааж явна. Хүчил, шүлт зэрэг идэмхий шингэн химийн бодисыг тээвэрлэхэд тусгай шилэн сав хэрэглэнэ. Шилэн сав нь гадуураа модон хайрцаг, шүлжсэн шээзгий, давхар савтай байна. Тээврийн хэрэгслийн тэвшинд шилэн савны хоолой /таг/-г дээш харуулж босоогоор хөдөлгөөнгүй байхаар бэхэлж ачна.

### 3.1.5 Удирдлага, зохион байгуулалтын талаар

“Химийн хортой болон аюултай бодисын тухай” Монгол улсын хууль Химийн хортой болон аюултай бодисыг импортлох, экспортлох, хил дамжуулан тээвэрлэх болон үйлдвэрлэх худалдах журам, Химийн хортой болон аюултай бодис хадгалах, тээвэрлэх ашиглах устгах журам, зэрэг хууль, журам тогтоол дүрэм зэргийг нарийн баримталж ажиллах

Тусгай зөвшөөрөл бүхий иргэн, аж ахуйн нэгж, байгууллага химийн хортой болон аюултай бодис худалдахдаа худалдан авсан этгээдийн хаяг, бодисын нэр, төрөл, хэмжээ, ашиглах зориулалтыг заасан баримтыг 2 хувь үйлдэн баталгаажуулж нэг хувийг худалдан авагчид, үлдсэн хувийг өөртөө хадгална.

Хадгалж байгаа химийн хорт болон аюултай бодисын сав баглаа боодол нь тухайн бодисын нэр, анхааруулах тэмдэг аюулын шинж чанарыг тод, томоор бичсэн шошготой байна.

Химийн бодисын ашиглалт, зарцуулалтын тайланг БОАЖЯ-нд жил бүрийн 11 дүгээр сарын 15-ны дотор гаргаж өгнө.

#### А. Орчныг бохирдлоос хамгаалах талаар

Харилцагч байгууллагуудаас химийн бодисын захиалга авахдаа тэдгээрийн нэр төрөл, тоо хэмжээг нарийн тодорхойлж аль болох борлуулалтаас үлдэгдэл гарч агуулахад хадгалагдахгүй байхаар зохион байгуулах

Импортоор оруулан авчрах химийн бодис, материал нэг бүрийн хими, физикийн шинж чанар, хор аюулын зэрэг, тээвэрлэлт, хадгалалтын онцлог нөхцлийн талаар нарийн тээвэрлэх, захиалагч байгууллагад нийлүүлэх, агуулахад хадгалах үйл ажиллагааны үед удирдлага болгох.

Химийн бодис, материалыг тээвэрлэхдээ зохих байгууллагаас зөвшөөрөл авч шаардлага хангасан сав, баглаа боодолтой, хагарч асгарч гэмтэхээргүй зөөлөвч жийрэгтэйгээр, нийтэд сэрэмжлүүлсэн таних тэмдэг, анхааруулсан тод бичигтэйгээр зориулалтын тээврийн хэрэгслээр тээвэрлэнэ.

Химийн онцгой хортой, хортой бодисын санамсаргүй алдагдал гарсан тохиолдолд хорыг саармагжуулах, ариутгал цэвэрлэгээ хийх, үлдэгдэл хаягдлыг устгах талаар яаралтай авч хэрэгжүүлэх зааварчлагыг бодис нэг бүрээр гаргаж компанийн ажиллагсад эзэмшүүлэх.

#### Б. Ажиллагсдын эрүүл ахуйг хамгаалах, хөдөлмөрийн нөхцлийг сайжруулах талаар

Үйлдвэрийн байрны агаар дахь температур, чийгшил, тоосжилтын түвшин зэрэгт хяналт тавих багаж хэрэгсэлтэй болох арга хэмжээг ойрын үед авах.

Ажиллагсад химийн бодис, материалыг ачих, буулгах, зөөх үедээ ажлын тусгай хувцас, техник хэрэгслийг ашиглан хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны дүрмийн шаардлагыг нарийн баримтлан ажилладаг дадал зуршлыг хэвшүүлэх.

Онцгой нөхцлийн үед ашиглах хөдөлмөр хамгааллын тусгай хувцас, багаж, техник хэрэгслийн зохих нөөцийг бүрдүүлэх.

Ажлын байранд мэргэжлийн хяналт, орчны мониторингын болон эрүүл ахуйн байгууллагаар тухай бүр хяналт хийлгэж, дүгнэлт гаргуулж байх. Өөрөөр хэлбэл ажлын байрын эрүүл ахуй, хөдөлмөр хамгааллын аттестатчилалд байнга хамрагдаж байх.

#### В. Сургалт судалгааны талаар

Тус компаний стратегийн болон ойрын зорилтыг хэрэгжүүлэхэд чиглэгдсэн технологийн менежмент (сургалт, сурталчилгаа, орчны хяналт)-ийг хөгжүүлэх, удирдлагын байгаль орчин, эрүүл ахуйн талаарх мэдээллийг сайжруулах.

УЛААНБААТАР ХОТЫН СҮХБААТАР ДҮҮРГИЙН 20-Р ХОРООНЫ НУТАГ  
ДЭВСГЭРТ БАЙРЛАХ “ОЙМСНЫ ҮЙЛДВЭР” ТӨСЛИЙН 2024 ОНЫ  
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Компанийн ажиллагсадад зориулсан байгаль орчин, үйлдвэрлэлийн экологийн талаар сургалтын хөтөлбөр боловсруулж, мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулах.

Химийн бодис, материалын үйлдвэрийн үйл ажиллагааг хэвийн явуулах, аливаа гэмтэл, ослоос урьдчилан сэргийлэх аргын үндэс болсон хөдөлмөр хамгааллын зааварчилгааг тогтмол өгч мөрдөлтөд нь байнга хяналт тавьж байх.

Хаягдал, бохирдолд тавих байгаль орчны салбарын олон улсын нормативыг технологийн үйл ажиллагааны дамжлага тус бүр дээр мөрдөж ажиллах, орчны хяналт шинжилгээг жил бүр тогтоосон хугацаанд хийлгэж хэвших.

### **БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, нөлөөллийн үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх зорилготой.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрөөс бүрдэнэ.

#### **Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө**

Энэхүү байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө /БОХТ/ нь төлөвлөж буй төслийн үйл ажиллагаанаас байгаль орчин, хүн амд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллүүдээс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээнүүдийг шаардагдах хөрөнгө зардал, хугацаа, давтамж, баримтлах дүрэм журам, стандартуудын хамт нэгтгэн үзүүлсэн болно.

Уг БОХТ-г төслийг хэрэгжүүлэгч “ЯНМАЛ” ХХК-аас заавал хэрэгжүүлж, мөрдөж ажиллах ёстой баримт бичиг юм.

Байгаль хамгаалах төлөвлөгөө нь байгаль орчныг хамгаалах арга хэмжээнүүдийн хураангуй бөгөөд жил бүр хянан үзэж, шинэчлэн сайжруулж байх шаардлагатай буюу байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрүүдээс гарч буй үр дүнтэй уялдуулж байх шаардлагатай.

#### **Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гол зорилт, хамрах хүрээ**

Химийн бодисыг хадгалах, ашиглах үйл ажиллагаанаас үзүүлж болох болзошгүй болон голлох нөлөөлөлд химийн бодисын хадгалалт, аюулгүйн ажиллагаа болон ажлын байрны эрүүл ахуйн бичил орчны нөлөөлөх байдал нь голлох нөлөөлөлд хамаарахаар байна.

Иймээс төсөл хэрэгжүүлэгч ажиллагсдын ажиллах орчин, хөдөлмөр хамгаалал, химийн бодисын эрсдлийн менежментийн асуудал дээр гол анхаарлаа хандуулж, 2007 оны 04 дугаар сарын 27-ны өдрийн 151/126/52 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан “Химийн хорт болон аюултай бодисыг хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах журам”, MNS 4585-98. Агаар орчны чанарын үзүүлэлт. Ерөнхий шаардлага, MNS 6458:2014. “Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй, Химийн хорт болон аюултай бодис бүтээгдэхүүний агуулах”, БНБД 21-04-05. Барилга байгууламжийн гал унтраах автомат төхөөрөмж, дохиоллын хэрэгсэл, MNS 5566:2005. Аж ахуйн нэгж байгууллагад зайлшгүй байх гал унтраах анхан шатны багаж хэрэгслийн шаардлага зэрэг стандартуудыг нарийн баримтлан ажиллаж, тухайн бодисын хор аюулгүйн лавлах мэдээлэл (MSDS)-д заагдсаны дагуу химийн бодис бүртэй харьцаж ажиллах шаардлагатай.

Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг жил бүрийн 12 дугаар сард багтаан хүлээн авч дараа оны төлөвлөгөө болон түүнийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө, зардлын хэмжээг Байгаль Орчин, Ногоон хөгжлийн Яаманд хүргүүлэн хянуулж, батлуулах шаардлагатай.

Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрт төслийн үйл ажиллагааны улмаас байгаль орчны төлөв байдалд үзүүлж байгаа өөрчлөлтийн хянах, шинжилгээ хийх, үр дүнг тайлагнах, түүнийг хэрэгжүүлэх арга хэлбэр, шаардагдах хөрөнгө, зардал, хугацааг тусгасан болно.

Төсөл хэрэгжүүлэгч байгаль орчныг хамгаалах талаар хүлээсэн үүргээ биелүүлэхийн баталгаа болгон тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээнд шаардагдах зардлынхаа 50-иас доошгүй хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгийг сум, дүүргийн Засаг даргын дэргэдэх байгаль орчныг хамгаалах тусгай дансанд төвлөрүүлж, төлөвлөгөөний биелэлтийг жил бүр тайлагнана.

УЛААНБААТАР ХОТЫН СҮХБААТАР ДҮҮРГИЙН 20-Р ХОРООНЫ НУТАГ  
ДЭВСГЭРТ БАЙРЛАХ “ОЙМСНЫ ҮЙЛДВЭР” ТӨСЛИЙН 2024 ОНЫ  
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

**Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд гарах зардал/төг/**

<b>№</b>	<b>Хэрэгжүүлэх арга хэмжээ</b>	<b>Тухайн жилийн зардал, (төг)</b>
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	<b>5000,0</b>
2	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	-
3	Дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөө	-
4	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох	-
5	Түүх, соёлын өвийг хамгаалах төлөвлөгөө	-
6	Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	<b>1300,0</b>
7	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	<b>470,0</b>
8	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэх	<b>115,0</b>
<b>НИЙТ ЗАРДАЛ</b>		<b>6885,0</b>

**УЛААНБААТАР ХОТЫН СҮХБААТАР ДҮҮРГИЙН 20-Р ХОРООНЫ НУТАГ ДЭВСГЭРТ БАЙРЛАХ “ОЙМСНЫ ҮЙЛДВЭР”  
ТӨСЛИЙН 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

*Сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, арга хэмжээний төлөвлөгөө*

<b>Гол ба болзошгүй сөрөг нөлөөллүүд</b>	<b>Урьдчилан сэргийлэх, бууруулах багасгах арга хэмжээ</b>	<b>Арга хэмжээний цар хүрээ</b>	<b>Нэгжийн өртөг /Мян.төг/</b>	<b>Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж</b>	<b>Баримтлах хууль журам стандарт</b>
<b>1. АГААР ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ БАГАСГАХ УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ</b>					
Үйлдвэрийн дотор орчинд болон химийн бодисын агуулахад түүхий эдээс үүдэлтэй тоосжилт болон химийн бодисын ууршилтын үр дүнд ялгарах хий зэрэг нь агаарын тоосжилт ба бохирдолтыг тодорхой хэмжээгээр нэмэгдүүлэх эх үүсвэр болно.	Үйлдвэрийн сүлжих цех болон бусад цех үйлдвэрүүдийн агааржуулалтын систем холбох, шүүлтүүр тавих	Агуулах орчимд	500,0	2024 он	MNS 0012-013:1991. Ажлын байрын агаар. Ажлын байрны агаарын бүс
	Орчны болон ажлын байрын агаарын бохирдлын байдалд шинжилгээ хийлгэх ( 2 удаа)		ОХШХ-т тусгасан	Хагас жилд 1 удаа	УСТ3384-82”. Агаар мандлын сорьц авахад тавих ерөнхий шаардлага
Агаарын бохирдлын улмаас ажлын нөхцөл, ажилчид болон нутгийн иргэдийн эрүүл мэндэд нөлөөлөх	Тоосноос эрүүл мэндээ хамгаалах нэг бүрийн хамгаалах хэрэгсэл, хүнсний нэмэлт бүтээгдэхүүнээр ажилчдыг хангах,	Ажиллах хугацаанд бүх хүнд	150.0	Сар бүр	Ажлын байрны агаарын эрүүл ахуйн шаардлага: MNS 4990:2010,
<b>Нийт</b>			<b>650,0</b>		
<b>1. УСАН ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ БАГАСГАХ УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ</b>					
Ус ашиглалт	Ундын усны нөөцн савыг эрүүл ахуйн шаарлага хангасан хүнсний зориулалтын сав ашиглах	Төслийн хүрээнд	ҮАЗ-д	2024	MNS 13.060.50 Усны чанарын стандарт Усны тухай хууль
	Ус ашиглалтын дүгнэлт гаргуулах , гэрээг байгуулж ажиллах, төлбөрийг цаг тухай бүр төлөх	Ажиллах нийт хугацаанд	Ашиглах усны хэмжээгээр	2024оны 10-р сард	ЗГ-ын 2013 оны 326 дугаар тогтоолын хавсралт –Ус ашигласаны төлбөрийн хувь хэмжээ/ Газар доорх усыг бохирдлоос хамгаалах: MNS3342:1982 БО, ЭМНХ-ын сайдын 1997 оны 143А, 352/А тоот хамтарсан тушаалын 2.3.5 хавсралт,
Ахуйн хог, хаягдал, бохир ус, шатах, тослох материал ба бусад хаягдлаас бага гүний уст давхарга болон хөрс ургамал бохирдох	ШТМ болон химийн бодисын хаягдал, асгаралт гаргахгүй байх хог хаягдал ил задгай хаяхгүй байх арга хэмжээ авах тусгай саванд цуглуулах	Үйл ажиллагааны турш	<b>100.0</b>	2024	



**УЛААНБААТАР ХОТЫН СҮХБААТАР ДҮҮРГИЙН 20-Р ХОРООНЫ НУТАГ ДЭВСГЭРТ БАЙРЛАХ “ОЙМСНЫ ҮЙЛДВЭР”  
ТӨСЛИЙН 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

<b>2. ХӨРС, УРГАМАЛАН БҮРХЭВЧИД ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ БАГАСГАХ УРЬДЁЙЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ</b>					
Хөрс элэгдэл эвдрэлд орж үржил шим, чийг буурах, гадаргын унаган хэлбэр өөрчлөгдөх	Хөрсөн бүрхэвчийг элэгдэх эвдрэхээс сэргийлэх арга хэмжээг тогтмол авч хэрэгжүүлэх	Үйлдвэрийн орч	100,0	2024	MNS 3307:1991, MNS 3308:1991 Хөрс. Хөрсний химийн элементүүдийн нийт хэмжээг тодорхойлох арга, MNS 5850:2008 Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ
	Хог хаягдал ил задгай хаях, тээврийн хэрэгсэлийн шатах тослох материал асгарах зэргээс бохирдож шинж чанараа алдахаас сэргийлэх зам талбайг хатуу хучилттай болгох зүлэг мод тарих	Төслийн орчимд	ҮАЗ	ҮАХүрээнд	
Орчны үзэмжийг сайжруулах, тоосжилтоос сэргийлэх, мод тарих	“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд нэгдсэн зохион байгуулалтаар ногоон зурвас /мод тарих/ байгуулах ажилд оролцох	Төв аймгийн Батсүмбэр суманд өөрийн эзэмшлийн газарт ойжуулалт хийнэ.	100 ш х 5.0=500,0	2024	
<b>Нийт</b>			<b>1350,0</b>		
<b>3. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТАЛААР</b>					
Гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх дохиоллын систем суурилуулах	Агуулахын ажиллагсад		100,0	2024н	Компанийн дотоод журмаар
Ажиллагсдыг жилд 1 удаа галын аюулаас урьдчилан сэргийлэх зорилгоор сургалт явуулах		250,0	1 удаа		
Химийн бодистой ажиллах аюулгүй ажиллагааны сургалт тогтмол зохиож байх		250,0	1 удаа		
Ажиллагсдыг эрүүл мэндийн үзлэгт хамруулах,		ҮАЗ	1 удаа		
Ажиллагсдыг хөдөлмөр хамгааллын хувцас хэрэглэлээ бүрэн хангах		ҮАЗ	2024		
Ажлын байранд аюулгүйн шүршүүр болон нүд угаах зориулалтын угаалтууртай болгох		ҮАЗ	2024 он		
Байгаль орчны төлөвлөгөөт аудитыг мэргэжлийн байгууллагаар 2 жил тутам хийлгэх	Төслийн нийт хугацаанд		3000,0	2024	Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 2-р бүлгийн 10 <sup>1</sup> дүгээр зүйлийн 1-д заасны дагуу
<b>ДҮН</b>			<b>3600,0</b>		
<b>Нийт дүн</b>			<b>4950,0</b>		

**УЛААНБААТАР ХОТЫН СҮХБААТАР ДҮҮРГИЙН 20-Р ХОРООНЫ НУТАГ ДЭВСГЭРТ БАЙРЛАХ “ОЙМСНЫ ҮЙЛДВЭР”  
ТӨСЛИЙН 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

**Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө**

Ангилал	Эх үүсвэрээс гарах хог хаягдлын төрөл	Код	Аюулын зэрэглэл	Жилд гарах нийт хэмжээ,	Хадгалах	Зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгж, байгууллагад нийлүүлэх	Хог хаягдал зайлуулахад гарах зардал, мян.төг	Баримтлах стандарт, аргачлал
Ахуйн	Хог хаягдлыг ил задгай хаяхгүй байх			8,7тн	Зориулалтын саванд	СБД ТҮК 10,0*12=120.0,	600,0	Хог хаягдлын тухай хууль
	Ангилан ялгаж тус тусад нь хийх савтай болгох				Ангилан ялгаж	50,0	250,0	
Шингэн	Шингэн хог хаягдлаар хөрс, газар доорх ус бохирдож болзошгүй	Хог хаягдалын тухай хуулийн /шинэчилсэн найруулга/ 10.3.6-д ААНБ-нь хөрс бохирдуулагч жорлон байгуулахыг хориглосон тул ЭКО-ОО ашиглах			Тогтмол хугацаанд			Хот суурины усан хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль, Хог хаягдлын тухай хууль болон холбогдох журам, заалтууд
		Бохирын цэгийн ариутгал халдваргүйжүүлэлтийг мэргэжлийн байгууллагаар улирал тутамд гүйцэтгүүлж байх			Тогтмол хугацаанд			
Аюултай	Хатуу	Хортой бодисын үлдэгдэл агуулсан эсвэл бохирдсон сав, баглаа боодол	15 0109*	X	Үүсэх хэмжээг тодорхойлох боломжгүй	+	+	1 сард 25000 төг x 12 сар =300.0
		<b>Шингээгч болон шүүлтүүрийн материал, бохир алчуур, тусгайлан заагдаагүй хамгаалалтын</b>	<b>15 02 01*</b>	<b>X</b>		+	+	
							<b>1150,0</b>	

Тайлбар

“X”- хяналттай хог хаягдлыг тэмдэглэгээгээр

“X” гэсэн тэмдэглэгээтэй хог хаягдлыг аюултай хог хаягдалд хамруулах эсэхийг шинжилгээгээр тогтоох ба аюултай шинж чанар үзүүлэгч бүрэлдэхүүнийг босго түвшинтэй тэнцүү болон түүнээс дээш хэмжээгээр агуулж байвал “аюултай” гэж үзнэ.

**УЛААНБААТАР ХОТЫН СҮХБААТАР ДҮҮРГИЙН 20-Р ХОРООНЫ НУТАГ ДЭВСГЭРТ БАЙРЛАХ “ОЙМСНЫ ҮЙЛДВЭР”  
ТӨСЛИЙН 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

**Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө**

Болзошгүй аюул, осол сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Нэгжийн өртөг (мян.төг)	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
Байгалийн давагдашгүй хүчин зүйл болж усны үер, гал гарч химийн бодис галд өртөж шатвал аюултай нөхцөл байдал үүснэ.	Байгаль хамгаалал, болзошгүй түймэр үерээс урьдчилан сэргийлэх талаар ухуулга, сурталчилгааныг самбар хийж байрлуулан, тухай бүрд нь шинэчилж байх	200.0	2024 онд	-
	Галын багаж хэрэгсэл авч ашиглахад бэлэн байдлаар байрлуулах (амьсгалын нэг бүрийн хамгаалалтын аппарат, галын хор, гал унтраагч, усан шүршүүр, гал унтраах хуурай хэрэгсэл, хөөс, нүүрсхүчлийн хий гэх мэт)	200.0	2024 онд	MNS8 5566:2005. Аж ахуйн нэгж байгууллагад зайлшгүй байх гал унтраах анхан шатны багаж хэрэгслийн шаардлага
Химийн бодис их хэмжээгээр асгарвал аюултай нөхцөл байдал үүснэ.	Бодис урвалжуудын хор аюулын зэргийг харуулсан тэмдэг, тэмдэглэгээг монгол тайлбараар дэлгэрэнгүй хийх	250.0	2024 онд	MNS 6458:2014. “Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй, Химийн хорт болон аюултай бодис бүтээгдэхүүний агуулах”
	Нэг бүрийн хамгаалах хэрэгсэл*, хоосон сав, бортого, бортого онгойлгогч, наалддаг шошго, металл юүлүүр, хүрз, хогийн шүүр, хориглох тэмдэг болон тууз зэрэг багаж хэрэгсэлийг бэлэн байлгах	350,0	2024 он-	
	Болзошгүй тохиолдлоор химийн бодис асгарсан тохиолдолд хэрэглэх зориулалтын шингээгч, хүнсний сод, хуурай элс, шороо, тогтворжуулагч, үртэс гэх мэт материалуудыг ажлын талбарт бэлэн байлгах	200.0	2024 онд	Тухайн бодисын хор аюулгүйн лавлах мэдээлэл (M808)
Осол эрсдлийн менежментийн төлөвлөгөөний нийт зардал		1200,0		

Төсөл хэрэгжүүлэх тухайн жилийн төлөвлөгөөний зардалд 7300,0 мян.төг төлөвлөж өгсөн

### **ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР**

Тухайн төслийг хэрэгжүүлснээс үүдэн байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг тухай бүр илрүүлэх, бууруулах, арилгах зорилгоор байгаль орчны төлөв байдал, шинээр үүсэн бий болсон нөхцөл байдалд ажиглалт, хяналт явуулах үйл ажиллагааны удирдамжийг **“орчны хяналт шинжилгээний хөтөлбөр”** гэнэ.

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тухайн төслөөс байгаль орчины бүрэлдэхүүн хэсэг /ус, хөрс, ургамал гэх мэт/ тус бүрт гарах бохирдол, аливаа өөрчлөлтийг хянах шинжилгээний арга аргачлал, хяналт шинжилгээ хийх хугацаа, сорьц авах болох хэмжилт хийх цэгийн байршил, баримтлах стандартууд зэргийг тодорхойлно.

Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөр нь төслийг хэрэгжүүлэх явцад үүссэн сөрөг нөлөөлөл, түүнийг бууруулах үйл ажиллагаа ямар үр дүнтэй байгааг илтгэх, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний үндэслэлийг боловсруулах, байгаль хамгаалах төлөвлөгөөг улам боловсронгуй болгох, байгаль орчноо хамгаалах, орон нутгийн захиргаа, хяналтын болон нутгийн оршин суугчдад бодитой мэдээлэл өгөхөд чухал ач холбогдолтой. ОХШХ нь БОХТ-тэйгээ нягт уялдсан бөгөөд байгаль орчныг хамгаалахаар авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний үр дүнг илэрхийлж, уг авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ үр ашигтай байгаа эсэхэд үнэлэлт дүгнэлт өгөх, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээнүүдэд юуг анхаарах шаардлагатайг зааж өгнө.

Байгаль орчныг хамгаалах тухай, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай Монгол Улсын хуулиудын дагуу батлагдсан арга, аргачлалаар, итгэмжлэгдсэн тоног төхөөрөмжөөр байгаль орчны хяналт шинжилгээний ажлыг явуулах шаардлагатай.

Тухайн жилд хийсэн хяналт шинжилгээний үр дүнгүүдийг жил бүрийн 12 дугаар сарын 1-ний дотор холбогдох төрийн захиргааны төв байгууллага /Байгаль орчин, ногоон хөгжлийн яам/-д хүргүүлэн хянуулж, дараа оныхоо төлөвлөгөөг батлуулж ажиллах ёстой.

Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрийг бүрэн хэрэгжүүлэх, батлагдсан арга, аргачлалаар дээжлэлт, хэмжилт хийх, холбогдох нарийвчлал, тохиргоог хангасан багаж тоног төхөөрөмжөөр шинжилгээг хийлгэх, үр дүнг шаардагдах нэгжийн системээр гаргах зэрэг бүхий л үйл ажиллагааг **“ЯНМАЛ” ХХК** хариуцах болно.

**УЛААНБААТАР ХОТЫН СҮХБААТАР ДҮҮРГИЙН 20-Р ХОРООНЫ НУТАГ ДЭВСГЭРТ БАЙРЛАХ “ОЙМСНЫ ҮЙЛДВЭР”  
ТӨСЛИЙН 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналт шинжилгээ хийх байршил	Хугацаа ба давтамж	Шаардагдах зардал (мян.төгрөг)	Баримтлах арга, аргачлал, стандарт, шаардлагууд
<b>1. Агаарын чанар</b>					
1.1	Агаарын бохирдлын (NO <sub>2</sub> , SO <sub>2</sub> , CO, Тоос) шинжилгээ хийлгэж байх	Агуулахын гадаа ба дотоод орчинд	Агаарын найрлага: жилд 1 удаа	Багажийн түрээсийн зардал: 1 багаж 40.0 х жилд 1 удаа* 5 жил <b>НИЙТ 200,0</b>	MNS 4585:2007 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага, MNS 3384:1982 Сорьц авахад тавих ерөнхий шаардлага, MNS 4048:1988 Тоосны хэмжээг тодорхойлох жингийн арга
1.2	Дуу шуугиан, чичиргээ: химийн ууршимтгай ба идэмхий хорт бодисууд		жилд 1 удаа	Багажийн түрээсийн зардал: 1 багаж 30.0 х жилд 1 удаа* 5 жил <b>НИЙТ 150,0</b>	MNS 0017-2-5-11:1988 Агаар дахь азотын давхар ислийн хэмжээг тодорхойлох фотоколориметрийн арга, MNS 5002:2000 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Шуугианы норм, аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага MNS ISO 226:2003 Дуу чимээ- хэвийн норм, түвшиний хэмжээ
<b>2. Хөрсний бохирдол</b>					
3.1	Хөрсний морфологи бичиглэл, рН, цахилгаан дамжуулалт, давс %, ялзмагийн агууламж %, шим тэжээлийн элемент (NO <sub>3</sub> , P <sub>2</sub> O <sub>5</sub> , K <sub>2</sub> O), хөрсний механик бүрэлдэхүүн, нүүрс устөрөгчийн нэгдлүүд, кадми, хром, кобальт, зэс, хар тугалга, мангани, никель, цайр	Төслийн талбайд 2 цэг сонгох /	Төслийн үйл ажиллагаа эхлэхээс өмнө 1 удаа Жилд 2 удаа	2 цэгт х 2 дээж х жилд 1 удаа х 5 жил /15.0+25.0/ <b>НИЙТ 800.0</b> /Хөрсний химийн шинжилгээ 1 дээж - 15.0 төг, хүнд металлын шинжилгээ 1 дээж- 25.0 төг/	MNS 3307:1991, MNS 3308:1991 Хөрс. Хөрсний химийн элементүүдийн нийт хэмжээг тодорхойлох арга, MNS 3309:1991 Хөрс. Хөрсний хялбар уусдаг давсны химийн найрлагыг тодорхойлох арга, MNS 3298:1991 Хөрс. Шинжилгээнд дээж авахад тавигдах ерөнхий шаардлага MNS ISO 11047:2001 Хөрсний чанар. Хөрсний усан орчны хандмалд кадми, хром, кобальт, зэс, хар тугалга, мангани, никель, цайрыг тодорхойлох. Дөлний болон цахилгаан дулааны атомын шингээлтийн спектрометрийн арга MNS 3675:1984 Хөрсний органик бодисын хэмжээг тодорхойлох лабораторийн арга MNS 5850:2008 Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ
<b>Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх ажлын 5 жилийн нийт зардлын дүн</b>				<b>1150.0</b>	

**Орчны хяналт, шинжилгээний нэг жилийн зардал**

Д/д	Шинжилгээний төрөл	Нэгжийн үнэ /мян.төг/	Дээжийн тоо	Бүгд үнэ /мян.төг/
1	Агаарын шинжилгээ	35.0	1	35.0
2	Хөрсний шинжилгээ	40.0	2	80,0
	Дүн			<b>115,0</b>

Орчны хяналт шинжилгээний зардалд 115,0 мян.төгрөг төсөвлөсөн болно.